



## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН ШИЙДВЭР НЭРЭМЖИТ ГУДАМЖ БОЛГОХ ТУХАЙ

2006 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Дархан

### Дугаар 52

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дугаар заалт, Засгийн газрын 1998 оны 234 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам”-ын 8 дугаар заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Монгол улс байгуулагдсаны 800, Дархан хотын 45 жилийн түүхт ойнууд тохиож байгаатай уялдуулан “Дархан Гурил тэжээл” ХК-ны уулзвараас стадион хүртэлх гудамжийг Дулаан үйлдвэрлэгчдийн, “ОСИБО” ХХК-ны уулзвараас Дархан дээд сургуулийн уулзвар хүртэлх гудамжийг Дархан-Өртөөний, Ус сувгийн уулзвараас ЗТАЖЯамны Тээврийн үйлчилгээний төвийн Дархан-Уул аймаг дахь салбарын уулзвар хүртэлх гудамжийг генерал Д.Бавуугийн нэрэмжит Цагдаагийн, Хүнсний үйлдвэрийн уулзвараас БХТНийгэмлэгийн уулзвар хүртэлх гудамжийг Хүнсчдийн нэрэмжит гудамж болгон тус тус нэрлэсүгэй.

ДАРГА Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ